БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Б.ЦЭРЭН

2025 оны .... сарын .... өдөр

БАГЦ 14. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 03 дугаар сарын 13 өдөр №.09/29. Улаанбаатар хот

Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрах, ажиллах, зорчих таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэхдээ замын хөдөлгөөнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй, аюулгүй байдлыг хангуулан ажиллах.

Ажлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам стандартын зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

1	Ажлын нэр	Багц 1. Хан-Уул дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний ажил
2	Үндэслэл, хэрэгцээ шаардлага	- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, А/154 дүгээр захирамж - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоол;
3	Байршил, талбайн хэмжээ	Чингисийн өргөн чөлөө урд хэсэг туслах авто болон явган зам талбай (Хан-Уул дүүрэг 19, 20, дугаар хороо) Нийт – 151,904 м.кв (хатуу хучилттай туслах авто болон явган зам талбай)
4	Гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
5	Захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Гүйцэтгэх байгууллага	Хот нийтийн аж ахуйн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй байна. **Нэг. Инженер техникийн ажилтны бүрэлдэхүүн:** Инженер-1 ХАБ-1 ЗТҮ-15 - Инженер– Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх - ХАБ- ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцах мэргэжилтэнтэй байх; - Зам талбайн үйлчлэгч **Хоёр. Машин, тоног төхөөрөмж** - Олон үйлдэлт ковш-2 - Хог тээвэрлэх машин (2 тн-оос дээш)-2 - Нуухны машин-2 - Давс цацагч машин-2 - Зам талбай чийгшүүлэх авто машин-1

		- Цас шүүрддэг түрдэг төхөөрөмж-5 - Явган замын үүрдэг үлээгч-10 - Бусад шаардлагатай гар багаж хэрэгсэл Гэрээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин, тээврийн хэрэгсэл нь замын хөдөлгөөний дүрмийг хангасан таних тэмдэгтэй байх, харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд тээврийн хэрэгслийн таних тэмдгийн өнгө, дүрслэл нь замын хөдөлгөөнд оролцогчдод тод харагдаж байх үүднээс гэрэл ойлгох шинж чанар бүхий гадаргуутай, эсхүл гадна талаасаа буюу дотроосоо гэрэлтүүлэгтэй байвал зохино.
7	Гүйцэтгэх ажлын тодорхойлолт	- Зам талбайн үйлчлэгчийн нэг удаагийн цэвэрлэх талбай 10000 м2-аас ихгүй байна. - Авто зам, автобусны зогсоолын цэвэрлэгээг зуны улиралд өглөөний цэвэрлэгээг 05:00-07:00 цаг, өвлийн улиралд 06:00-08.00 цагийн хооронд бүрэн цэвэрлэж авто машин, явган зорчигч саадгүй зорчих нөхцлийг хангана. - Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүй цэвэрлэгээг хийнэ. - Өвлийн улиралд хариуцсан автозамын халтиргаа гулгааг цас орсон даруйд нягтаршиж, мөстөхөөс өмнө халтиргаа, гулгаа арилгах тусгай зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэх; - Нийтийн эдэлбэр газар, зам талбайн цэвэрлэгээг дараах дарааллаар гүйцэтгэнэ. а. Автобусны буудлын цэвэрлэгээ, хогийн сав суллах; б. Авто замын зорчих хэсгийн дагуух цэвэргээ, нуух цэвэрлэгээ в. Явган хүний замын цэвэрлэгээ; г. Нийтийн эдэлбэр газрын эд хөрөнгө дээр наасан, зурсан зар сурталчилгааг хуулах, арилгах; д. Нийтийн эдэлбэр газар, гудамж, талбайн хогийн сав суллах е. Хананаас хана хүртлэх түүвэр хогийн цэвэрлэгээ ё.Үерийн ус зайлуулах хоолой далан суваг цэвэрлэгээ - ж. Хайс, хашлага, архитектурын байгууламж угаах
8	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Улаанбаатар хотын зам талбайн ажил үйлчилгээ үйл ажиллагаанд мөрдөгдөж буй стандартыг мөрдөж, эдийн засгийн тооцоо болон төсвийг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох
9	Гүйцэтгэх ажлын тодорхойлолт	**<u>Монгол Улсын хуулиуд</u>** - Хог хаягдлын тухай хууль **<u>Норм, нормативууд:</u>** - "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"

		- “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, авулгүй ажиллагааны удирдамж” UCS 1704A хотын стандарт - “Орчны аюулгүй байдал UCS0001-01:2019” зэрэг бусад шаардлагатай норм дүрмүүдийг дагаж мөрдөх, биелүүлэх. Бусад холбогдох норм, дүрэм
10	Тайлагналт	Захиалагчаас гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хагас жил, жилийн эцсээр дүгнэж, үр дүнгээс хамааран гэрээг сунгах, цуцлах эрхтэй. Гүйцэтгэгч сар бүр гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, түүнтэй холбогдох баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартыг ханган боловсруулж, холбогдох нэгж, албан тушаалтнаар баталгаажуулж, ирүүлнэ.

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ТУЯАЦЭЦЭГ

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Э.БААТАРСҮРЭН

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Т.РАЙСА

ХОГ ТЭЭВЭР, ЗАМ, ЦЭВЭРЛЭГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН — С.БОЛОРМАА

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны 03
дугаар сарын 13 өдрийн 09/26 дугаар
ажлын даалгаврын хавсралт

БАГЦ-14 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН БАЙРШИЛ, ТОО ХЭМЖЭЭ

№	Гудамж, талбайн нэршил	Хороо	Эхлэл, төгсгөлийн цэгийн байршил	Авто замын урт	Авто замын өргөн	Талбайн хэмжээ	Тариф /₹/	Сард цэвэрлэх давтамж
1	Б.Шаравын гудамж	19	Хөрш заан хотхон хүртэл тойрсон туслах зам талбай	3,260	10	32,600	70	11
2	Соёлын ордон орчмын туслах замууд	19	Б.Шаравын гудамжнаас Сүмбэр таурын урд талаар Соёлын ордон, BSB хүртэл туслах замууд	644	10	6,440	70	11
3	Ээрмэлийн гудамж	19	75-р сургуулийн уулзвараас Ээрмэлийн үйлдвэр хүртэл	828	10	8,280	70	11
4	Богд Жавзандамбын гудамж	19	Ээрмэлийн үйлдвэрээс Оргил худалдааны төв хүртэл	480	10	4,800	70	11
5	Туул гол гудамж	19	Зайсангийн гудамжнаас Хөрш заан хотхон хүртэл	1,450	10	14,500	70	11
6	115-р сургуулийн арын туслах зам	19	115-р сургуулийн арын туслах зам	120	10	1,200	70	11
7	Туслах зам	19	Зайсангийн гудамжнаас 44-р байр хүртэл туслах зам	296	10	2,960	70	11
8	Туслах зам	19	Туул гол гудамжнаас Шинэзуун билэг сургууль хүртэл туслах зам	240	10	2,400	70	11
9	Туслах зам	19	Миний гэр хотхон, 56д, в байр орчмын туслах замууд	400	10	4,000	70	11
10	Эко зурвас	19, 20	Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл унадаг дугуйн зам, явган зам	1,700	10	17,000	70	11
11	Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байр орчим	20	ХУД-ийн ЗДТГ-ын орчин буюу бусад аж ахуйн нэгж албан газруудын салбар замууд	1,200	10	12,000	70	11
12	Б.Шаравын гудамжнаас Чингисийн өргөн чөлөө хүртэл	20	Б.Шаравын гудамжнаас Чингисийн өргөн чөлөө хүртэл /Цагаан хаалганаас Номин юнайтед худалдааны төвийн баруун талаар/	1,044	10	10,440	70	11
13	Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбосон зам	19	Улбаанбаатар сувилалаас Номин агуулахын уулзвар хүртэл	4000	7	28,000	70	11
14	Чингисийн өргөн чөлөөнөөс мишээл худалдааны төвийн баруун талаар салсан туслах зам	20	ЧӨЧ-с Цаг уур 86, 89-р байрны уулзвар хүртэл	414	10	4,140	70	11
15	Хөрш заан хотхоны туслах зам	20	Шаравын гудамжны төгсгөлөөс Хөрш заан хотхон руу эргэсэн зам	262	12	3,144	70	11
						151,904		